


# **Санхүүгийн тайлан ба Хараат бус аудиторын тайлан “Улаанбаатар БҮК” ХК**

2024 оны 12 дугаар сарын 31



# Удирдлагын мэдэгдэл

Удирдлага нь санхүүгийн тайланг үнэн зөв бэлтгэж, компанийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний байдлаарх санхүүгийн байдал, уг өдрөөр дуусвар болсон үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу зохистой толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг бэлтгэхдээ удирдлага дараах үүрэг хариуцлагыг биелүүлсэн. Үүнд:

- Нягтлан бодох бүртгэлийн тохиромжтой бодлогыг сонгох, тууштайгаар даган мөрдөж, үндэслэлтэй, нягт нямбай тооцоолол, үнэлгээ хийж, бүх холбогдох нягтлан бодох бүртгэлийн стандартыг мөрдсөн.
- Компанийн эд хөрөнгийг хадгалан хамгаалах, аливаа заль мэх, зүй бус үйлдлээс сэргийлэх, ийм үйлдлийг илрүүлэхэд шаардлагатай арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн.
- Санхүүгийн тайланг тасралтгүй үйл ажиллагаанд үндэслэн бэлтгэсэн.
- Ангурсен үйл явдлын үр дүнд хуупмийн дэгүү өсвөл үүсмэл үүрэг хариуцлагыг хүлээсэн, ирээдүйн үйл ажиллагаанд алдагдал хүлээж болзошгүй зүйлсийг байнга хянаж байх үүрэгтэй бөгөөд хуулийн дагуу өсвөл үүсмэл үүрэг хариуцлагыг, бийтээшигийн зүйлсийн талдаар тодруулсан.

"Улаанбаатар БҮК" ХК-ийн ТҮЗ-ийн дарга Д.Нямхүү, Гүйцэтгэх захидал Х.Золжаргал болон Санхүү бүртгэлийн албаны дарга Ч.Цэлгэрмаа өндөр энэхүү тайлангийн 9-15 дугаар хуудсанд үзүүлсэн компанийн санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх компанийн санхүүгийн байдал, уг өдрөөр дуусгавар болсон жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээ Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлсэн гэдгийг үүгээр мэдэгдэж байна.



## “ГРАНТ ТОРНТОН АУДИТ” ХХК

Аудит, татвар, зөвлөх үйлчилгээний дэлхийн сүлжээний бие даасан фирм

Далай тауэр, 9 давхар  
ЮНЭСКО-ийн гудамж-31  
Сүхбаатар дүүрэг,  
1-р хороо, Улаанбаатар  
14230, Монгол Улс  
Т + 976 70 110711  
+ 976 70 110799

# Хараат бус аудиторын дүгнэлт

## “Улаанбаатар БҮК” ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд:

### Дүгнэлт

Бид Улаанбаатар БҮК” ХК (цаашид “компани” гэх) -ийн 2024 оны 12 дугаар сарын 31-нээрх дараах санхүүгийн тайлангуудад (цаашид “санхүүгийн тайлан” гэх)-д аудит хийлээ. Үүнд:

- Санхүүгийн байдлын тайлан,
- Орлогын дэлгэрэнгүй тайлан,
- Өмчийн өөрчлөлтийн тайлан,
- Мөнгөн гүйлгээний тайлан болон
- Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогын хураангуй,
- Материаллаг нягтлан бодох бүртгэлийн бодлогын мэдээлэл болон бусад тайлбар тодруулгууд.

Бидний дүгнэлтээр, “Улаанбаатар БҮК” ХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн байдал ба уг өдрөөр дуусгавар болсон жилийн санхүүгийн үр дүн ба мөнгөн гүйлгээ нь бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын олон улсын стандарт (АОУС)-уудын дагуу хийж гүйцэтгэв. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагаа энэ тайлангийнхаа Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлагаа гэсэн хэсэгт харуулав.

### Хараат бус байдал

Бид Нягтлан бодогчдын ёс зүйн олон улсын стандартын зөвлөлийн Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм болон Монгол улсын мэргэшсэн нягтлан бодогчдын Ёс зүйн дүрмийн санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой ёс зүйн зохих шаардлагуудын дагуу тус компаниас хараат бус бөгөөд эдгээр ёс зүйн шаардлагуудад нийцүүлэн ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Олж авсан аудитын баримт нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтийн үндэслэл болоход хангалттай, зохистой гэж итгэж байна.



## Аудитын аргачлалын хураангуй

<b>Аудитын гол асуудлууд</b>	<ul style="list-style-type: none"> <li>Тайлант жилийн санхүүгийн тайландаа хийсэн аудитад хамгийн их ач холбогдолтой нөлөө бүхий асуудал юм.</li> </ul>
<b>Материаллаг байдал</b>	<ul style="list-style-type: none"> <li>Санхүүгийн тайлангийн аудитад ашигласан нийт материаллаг байдал нь 869,101.3 мянган төгрөг ба материаллаг байдлыг сонгоходоо борлуулалтын орлогын 2 хувиар тооцсон.</li> </ul>
	<ul style="list-style-type: none"> <li>Компанийн зорилго нь том бүтээн байгуулалтад тогтвортой оролцох, хэрэглэгчийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлж зах зээлийн нэр хүнд, тэргүүлэгч байр сууриа бэхжүүлэх бөгөөд татварын өмнөх ашиг нь санхүүгийн тайлангийн хэрэглэгчдийн анхаарлыг хандуулах үзүүлэлт тул борлуулсан бүтээгдэхүүний борлуулалтын орлогод эдийн засгийн нөхцөл байдал ихээхэн нөлөөлж байгаа учир материаллагийн суурь үзүүлэлтээр сонгосон.</li> <li>Гүйцэтгэлийн материаллаг байдлыг нийт материаллаг байдлын дүнгийн 75 хувиар буюу 651,826.0 мянган төгрөгөөр тогтоосон.</li> </ul>

## Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн үнэлэмжээр аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлууд юм. Санхүүгийн тайландаа хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг тусдаа байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн тусдаа дүгнэлт гаргаагүй болно.

Аудитын гол асуудал	Хариу арга хэмжээ
<b>Орлого хүлээн зөвшөөрөлт</b>	<p>Тайлант жилийн орлогын дүн 13,166,060.6 мянган тогрог байна. Компании ход ходоо төрлийн бизнесийн үйл ажиллагаа эрхэлж, орлого олдог. Орлого хүлээн зөвшөөрөх хугацаанд гэрээ тус бүрээр дүн шинжилгээ хийх шаардлагатай. Орлого хүлээн зөвшөөрөх бүртгэлийн бодлогыг энэхүү тайлангийн тодруулга <b>4.12-д</b> дурдсан.</p> <p><b>Хойшлогдсон татвар</b></p> <p>Үр ашигт татварын түвшин 10% байна. Тайлант хугацааны борлуулалтын орлогын хэмжээ өмнөх оныхоос 6,557,175.1 мянган төгрөгөөр өссөнтэй холбогдох татварын өмнөх ашиг 6 тэрбум төгрөгөөс хэтрээгүй тул 10%-иар орлогын татвар тооцогдсонтой холбоотой.</p> <p>Санхүүгийн байдлын тайландаа тайлант хугацааны орлогын татварын өглөг 352,057.7 мянган төгрөг, хойшлогдсон татварын өр төлбөр 275,659.9 мянган төгрөг тус тус байна. Дэлгэрэнгүй орлогын тайландаа тусгасан 532,889.0 мянган төгрөгийн татварын зардал нь татварын өмнөх ашигийн 11%-ийг эзэлж байна. Тайлант хугацааны болон хойшлогдсон татварын үлдэгдлийг тодруулга <b>13-д</b> харуулсан.</p>
	<p>Үид орлогын шинэ ургсгалыг тодорхойлох зорилгоор хүлээн зөвшөөрсөн орлогод дүн шинжилгээ хийж, орлогын шинж чанарыг үнэлж, орлого бүртгэх хугацаа болон гэрээнд дурдсан аливаа онцгой шинжтэй нөхцөлүүдийг шинжилсэн.</p> <p>Ингэхдээ үид орлогын дүнг гэрээтэй тулгаж, цар хүрээ, цаг хугацаа болон харилцагчтай ажил эсвэл бараа хүлээлцсэн акт зэрэг руу тулган шалгасан.</p> <p>Бид тайлант хугацааны татварын нөөц, хойшлогдсон татварын хөрөнгийн хүлээн зөвшөөрөлт, нөхөгдөх байдал зэрэг хамаарах хяналтын бүрдэлт, түүний хэрэгжилтийг үнэлсэн.</p> <p>Бид компанийн бодлогын хэрэгжилт, тайлант хугацааны болон хойшлогдсон татварын хяналт зэргийн зохицтой эсэхийг удирдлагатай зөвшилцсэн.</p> <p>Бид тайлант хугацааны болон хойшлогдсон татварын тооцооллыг хийхдээ компанийн гүйцэтгэдэг процедурыг шалгаж, холбогдох татварын тооцооллыг аудитласан.</p>



## Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлд хариуцлага хүлээнэ. Бусад мэдээлэл компанийн 2024 оны 12 дугаар сарын 31-нээрх жилийн тайланд багтсан мэдээллээс бүрдэх ба харин санхүүгийн тайлан болон манай аудиторын тайланг багтаахгүй. Жилийн тайлан нь энэхүү аудиторын тайлан гарсан өдрөөс хойш бидэнд нээлттэй болно.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй бөгөөд бид аливаа хэлбэрээр баталгаажуулалтын дүгнэлт илэрхийлэхгүй.

Санхүүгийн тайланд бидний хийсэн аудиттай холбоотой бидний үүрэг хариуцлага бол дээр тодорхойлсон бусад мэдээлэл бидэнд нээлттэй болсон үед уншиж танилцах, ингэхдээ уг бусад мэдээлэл нь санхүүгийн тайлан эсвэл аудитаар бидний олж авсан мэдлэгтэй материаллаг хэмжээгээр харшилж байгаа эсвэл өөрөөр материаллаг байдлаар буруу илэрхийлэгдсэн эсэхийг авч үзэх юм.

### Удирдлага болон Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг хариуцлага

Компанийн удирдлага эдгээр санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэх, үнэн зөв толилуулах үүрэгтэй. Удирдлагын тодорхойлох энэхүү дотоод хяналт нь санхүүгийн тайланг аливаа алдаа эсвэл залилангийн улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай байдаг.

Удирдлага нь санхүүгийн тайланг бэлтгэхдээ компанийн үйл ажиллагааг зогсоох юмуу татан буулгахаар төлөвлөсөн эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудыг гаргахдаа тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах компанийн чадамжийг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагатай байна.

### Санхүүзиийн тайлээшиллийн аудитад хүлсөх аудиторын үүрэс хариуцласа

Залилан эсвэл алдаанаас үссэн материаллаг буруу илэрхийлээс санхүүгийн тайланг нь бүхэлдээ анги эсэх талаарх ул үндэслэлтэй нотолгоо олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Ул үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндер түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитаар оршин байгаа материаллаг алдаа зөрчлийг илрүүлдэг гэсэн нотолгоо болохгүй.

Буруу илэрхийлэх явдал нь залилан эсвэл алдаанаас үүсч болох ба хэрэв тэр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогддог.

### Аудитор нь залилан эсэх хуулын тайлбарын үзүүллийн нийтийн цэргүүдийн тайланын тайлбар

АОУС-ын дагуух аудитын нэг хэсэг байдлаар бид мэргэжлийн шийдэл ашиглаж аудитын ажлын явцад мэргэжлийн үл итгэх үзлийг хандлагыг баримтлан ажилладаг. Үүнд:

- Залилан эсвэл алдааны улмаас санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийлэгдэх эрсдэлийг тодорхойлж, түүнийг үнэпэн уг эрсдэлд тохирохуйц аудитын горимыг боповсрууран хэрэгжүүлж өөрсдийн дүгнэлтийнхээ үндэслэл болохуйц хангапттай, тохиромжтой аудитын баримт нотолгоог олж авдаг. Залилангаас үссэн материаллаг буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үссэн буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэлээс харьцангуй их байдаг, учир нь залиланд хувалдаан, бичиг баримт хуурчмаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу илэрхийлэх болон дотоод хяналтыг орхигдуулах явдлууд багтсан байж болно.



- Компанийн дотоод хяналтын үр ашигтай байдалд санал дүгнэлт өгөх зорилгоор биш харин тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горим боловсруулах зорилгоор аудитын ажилтай холбоотой дотоод хяналтын талаар ойлголт олж авдаг.
- Удирдлагын ашигласан нягтлан бодох бүртгэлийн бодлогын тохиромжтой байдал, нягтлан бодох бүртгэлийн тооцоолол болон холбогдох тодруулгын ул үндэслэлтэй, байдлыг үнэлдэг.
- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, мөн олж авсан аудитын баримт нотолгоонд үндэслэн Компанийн тасралтгүй үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэхүйц үйл явдал, нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал оршин байгаа эсэхийг тодорхойлдог. Хэрэв материаллаг хэмжээний тодорхой бус байдал оршин байна гэж үзвэл аудиторын тайландaa санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгад анхаарал хандуулах эсвэл ийм тодруулга хийх нь хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудиторын тайлан гарах өдөр хүртэлх олж авсан аудитын баримт нотопгоондoo үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал, эсвэл нөхцөл байдал Компани тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах боломжгүй болгоход хүргэж болно.
- Тодруулгыг багтаагаад санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулга, бүтэц, агуулгыг үнэлж санхүүгийн тайланд үнэн зөв толилуулгын шаардлагыг хангахуйц хэмжээнд гол гол ажил үйлгээ, үйл явдлыг ишэрийлсэн эсэхийг тодорхойлдог.
- Санхүүгийн тайланд дүгнэлт өгөх зорилгоор компани доторх бизнесийн үйл ажиллагааны санхүүгийн мэдээллийн талаар хангалттай зохистой нотолгоо олж авдаг. Бид компанийн аудитын чиглүүлэх, хянах, түйцэтгэх үүрэгтэй. Бид зөвхөн өөрсдийн аудитын дүгнэлтдээ хариуцлага хүлээнэ.

Бид аудитын ажлын төлөвлөсөн хамрах хүрээ, цаг хугацаа болон аудитын явцад олж илрүүлсэн дотоод хяналтын мэдэгдэхүйц доголдлыг багтаагаад нөлөө бүхий аудитын илрүүлэлтүүд, бусад томоохон асуудлуудаар засаглах эрх мэдэл бүхий удирдлагатай харилцдаг.

Бид хараат бус байдлын талаар холбогдох ёс зүйн шаардлагуудад нийцсэн гэдгээ засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдэд мэдэгддэг ба мөн бид тэдгээр хүмүүстэй бүх харилцаа холбоо болон ширээлжилж бий болгоход хамгийн түүрэгтэй бидний хараат бус байдлын хураанд бодолцож үзвэл зохих асуудлуудаар харилцдаг.

### *Бусад хууль тогтоомж, зохицуулалтын шаардлагын талаар*

Монгол улсын Компанийн тухай хуулийн 92, 94-р зүйлд заасны дагуу сонирхлын зөрчилтэй этгээдтэй хийсэн ажил гүйлгээ, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Санхүүгийн Зохицуулах Хороо болон Монголын Хөрөнгийн Биржээс тогтоосон бусад мэдээлэл, Компанийн дүрэмд заасан бусад мэдээллийг тайлагнах үүрэгтэй бөгөөд эдгээр зүйлстэй холбоотой ямар нэгэн зөрчил илрээгүй болно.

Энэхүү Хараат бус аудиторын тайланг гаргахад оролцсон гэрээт ажлын Партнер нь Н.Эрдэнэцог болно.



Н.ЭРДЭНЭЦОГ  
ГЭРЭЭТ АЖЛЫН ПАРТНЕР

Огноо: .....

Санхүүгийн тайлангийн нэмэлт тодруулгууд  
2024 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон жилийн хувьд (өөрөөр тусгайлан заагаагүй бол мянган төгрөгөөр илэрхийлэв)

# Санхүүгийн байдлын тайлан

Мянган төгрөгөөр	Тодруулга 12 сарын 31-ний улдэгдэл	2024 оны 12 сарын 31-ний улдэгдэл	2023 оны 12 сарын 31-ний улдэгдэл
<b>Хөрөнгө</b>			
<b>Эргэлтийн хөрөнгө</b>			
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	7	167,851	303,662
Дансны болон бусад авлага	8	2,203,873	5,029,381
Бараа материал	9	34,240,536	30,240,400
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	10	1,112,747	9,007
<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>		<b>37,725,007</b>	<b>43,590,510</b>
<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>			
Үндсэн хөрөнгө, цэвэр	11	36,566,522	36,854,263
Биет бус хөрөнгө, цэвэр	12	9,317	18,634
Дуусаагүй барилга	13	2,964,905	-
<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>		<b>39,540,744</b>	<b>36,872,897</b>
<b>Нийт хөрөнгө</b>		<b>77,265,751</b>	<b>80,463,407</b>
<b>Өр төлбөр ба ээдийн өмч</b>			
<b>Өр төлбөр</b>			
<b>Богино хугацаат өр төлбөр</b>			
Дансны болон бусад өглөг	15	12,738,419	26,825,838
Урьдчилж орсон орлого	16	416,820	860,430
<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>		<b>13,155,239</b>	<b>27,686,268</b>

Санхүүгийн тайлангийн нэмэлт тодруулгууд  
2024 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон жилийн хувьд (өөрөөр тусгайлан заагаагүй бол мянган төгрөгөөр илрхийлгэв)

## Санхүүгийн байдлын тайлан (ургэлжлэл)

Мянган төгрөгөөр	Тодруулга	2024 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	2023 оны 12 сарын 31-ний үлдэгдэл
<b>Урт хугацаат өр төлбөр</b>			
Хойшлогдсон татварын өр төлбөр	14	275,660	283,859
Бусад урт хугацаат өр төлбөр	17	7,351,787	-
<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>			
		<b>7,627,447</b>	<b>283,859</b>
<b>Өр төлбөрийн нийт дүн</b>			
		<b>20,782,686</b>	<b>27,970,127</b>
<b>Эздийн өмч</b>			
Хувийн өмч	18.1	131,547	131,548
Нэмж төлөгдсөн капитал	18.2	7,225,920	7,225,920
Хөрөнгийн дахин үнэлгээний өөрчлөлт	18.3	26,092,531	26,587,885
Хуримтлагдсан ашиг	18.4	23,033,067	18,547,927
<b>Эздийн өмчийн дүн</b>			
		<b>56,483,065</b>	<b>52,493,280</b>
<b>Өр төлбөр ба эздийн өмчийн дүн</b>			
		<b>77,265,751</b>	<b>80,463,407</b>

Уг санхүүгийн байдлын тайланг 2025 оны 03 дугаар сарын 04-ны өдөр батлав:



Ө.Дэлгэрмаа  
Санхүү бүртгэлийн апбаны дарга

Хуудас 16 - 43-д харуулсан тодруулгууд нь энэхүү санхүүгийн байдлын тайлангийн салшгүй нэг хэсэг болно.

Санхүүгийн тайлангийн нэмэлт тодруулгууд  
2024 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон жилийн хувьд (өөрөөр тусгайлан заагаагүй бол мянган төгрөгөөр илэрхийлэв)

## Орлогын дэлгэрэнгүй тайлан

Мянган төгрөгөөр	Тодруулга	2024 он	2023 он
Орлого	19	13,155,070	36,807,801
Өртөг	20	(25,258,843)	(21,258,576)
<b>Нийт ашиг</b>		<b>18,196,227</b>	<b>15,639,318</b>
Түрээсийн орлого	21	162,327	157,001
Хүүний орлого	22	1,932	66
Бусад орлого		251,400	6,706
Борлуулалт, маркетингийн зардал	23	(262,709)	(207,430)
Ерөнхий ба удирдлагын зардал	24	(12,721,712)	(14,915,999)
Санхүүгийн зардал	22	(457,645)	-
Бусад зардал	25	(554,684)	(234,635)
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз		-	2,039
Гадаад валютын ханшийн зөрүүний олз	25	72,229	2,000
Бусад зардал		(33,143)	-
<b>Татвар төлөхийн өмнөх ашиг</b>		<b>4,654,222</b>	<b>449,156</b>
Орлогын татварын зардал	27	(532,889)	(72,017)
<b>Татварын дараах ашиг</b>		<b>4,121,333</b>	<b>377,139</b>

Санхүүгийн тайлангийн нэмэлт тодруулгууд  
2024 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон жилийн хувьд (өөрөөр тусгайлан заагаагүй бол мянган төгрөгөөр илэрхийлэв)

## Орлогын дэлгэрэнгүй тайлан (ургэлжлэл)

Мянган төгрөгөөр	Тодруулга	2024 он	2023 он
<b>Бусад дэлгэрэнгүй орлого</b>			
Хорооцго оруулалтын үзүүлэлийн нийт		(495,354)	(537,078)
<b>Бусад дэлгэрэнгүй орлогын дүн</b>		3,625,979	(159,938)
<b>Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг</b>		31.33	2.87

Хуудас 16 - 43-д харуулсан тодруулгууд нь энэхүү орлогын дэлгэрэнгүй тайлангийн салшгүй нэг хэсэг болно.

Санхүүгийн тайлангийн нэмэлт тодруулгууд  
2024 оны 12 сарын 31-нээр дуусвар болжин жилийн хувьд (өөрөөр тусгайлан заагаагүй бол  
мянган төгрөгөөр илэрхийлэв)

## Өмчийн өөрчлөлтийн тайлан

Мянган төгрөгөөр	Тодруулга	Хувьцаат капитал	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт өмч
2024 оны 01 сарын 01-ний үлдэгдэл	18	131,548	7,225,920	26,587,885	18,547,927	52,493,280
Тайлант үеийн цөвэр ашиг (алдагдал)	18.4	-	-	-	4,121,333	4,121,333
Зарласан ногдол ашиг	15	-	-	-	(131,548)	(131,548)
Дахши үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	18.3	-	-	(495,354)	495,354	-
2024 оны 12 сарын 31-ний үлдэгдэл		131,548	7,225,920	26,092,531	23,033,066	56,483,065

Хуудас 16 - 43-д харуулсан тодруулгууд нь энэхүү өмчийн өөрчлөлтийн  
тайлангийн салшгүй нэг хэсэг болно.

Санхүүгийн тайлангийн нэмэлт тодруулгууд  
2024 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон жилийн хувьд (өөрөөр тусгайлан заагаагүй бол мянган төгрөгөөр илэрхийлэв)

## Мөнгөн гүйлгээний тайлан

Мянган төгрөгөөр	Тодруулга	2024 он	2023 он
<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>			
<b>Мөнгөн орлогын дүн</b>	<b>41,961,022</b>	<b>41,777,809</b>	
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	41,669,394	41,463,902	
Даатгалын нэхвэрээс хүлээн авсан мөнгө	683	37,782	
Бусад мөнгөн орлого	290,945	276,125	
<b>Мөнгөн зарлагын дүн</b>	<b>(31,107,942)</b>	<b>(37,454,564)</b>	
Ажиллагчдад төлсөн	(8,648,934)	(7,542,093)	
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	(2,209,807)	(2,436,129)	
Бараа материал худалдан авахад төлсөн	(8,426,113)	(17,347,455)	
Ашиглалтын зардалд төлсөн	(871,077)	(1,020,959)	
Түвш шатахуун, тээврийн хэлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	(5,050,801)	(5,310,006)	
Хүүний төлбөрт төлсөн	(457,645)	-	
Татварын байгууллагад төлсөн	(3,583,802)	(2,670,033)	
Даатгалын төлбөрт төлсөн	(26,349)	(26,644)	
Бусад мөнгөн зарлага	(924,321)	(1,092,345)	
<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>10,853,080</b>	<b>4,323,245</b>	
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>			
<b>Мөнгөн орлогын дүн</b>	<b>2,231</b>	<b>66</b>	
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	300	-	
Хүлээн авсан хүүний орлого	1,931	66	

Санхүүгийн тайлангийн нэмэлт тодруулгууд  
2024 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон жилийн хувьд (өөрөөр тусгайлан заагаагүй бол мянган төгрөгөөр илэрхийлэв)

## Мөнгөн гүйлгээний тайлан (ургэлжлэл)

Мянган төгрөгөөр	Тодруулга	2024 он	2023 он
Мөнгөн зарлагын дүн		(120,410)	(59,070)
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсэн		(120,410)	(59,070)
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		(118,179)	(59,004)
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
Мөнгөн орлогын дүн		12,950,000	1,762,000
Зээлт авсан, өрийн үнэт цаасыг гаргаснаас хүлээн авсан		12,950,000	1,762,000
Мөнгөн зарлагын дүн		(23,815,000)	(6,236,000)
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		(23,815,000)	(6,236,000)
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		(10,865,000)	(4,474,000)
Валютын ханшийн зөрүү		(5,712)	(52,755)
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ		(135,811)	(262,514)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	7	303,662	566,176
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	7	167,851	303,662

Хуудас 16- 43-д харуулсан тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй нюг хосог болно.